

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 04 сарын 29 -ны өдөр

Дугаар 2015/01

Улаанбаатар хот

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Соёлын ордонд 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 15:07 цагт эхлэв.

Хурлын ирц:

Тооллогын комиссын гишүүн Ю.Болорцэцэгийн танилцуулснаар: “ҮЦТТТХТ-с 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгон авсан мэдээллээс 69,969,851 хувьцаа эзэмшдэг 180 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох 74,287,700 ширхэг энгийн хувьцаанаас 94,19% болж байгааг хуралд оролцогсод болон хурлын даргад мэдээллэв. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.”

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2015/08 тоот тогтоолын танилцуулж, Хурлын даргаар томилогдсон АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгийг индэрт урилаа.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын дарга “хэлэлцэх асуудал”-ыг танилцуулах:
 1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
2. Хэлэлцэж байгаа асуудлуудад холбогдсон асуулт, хариулт;
3. Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах;
4. Санал хураалт явуулах;
5. Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах;
6. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах;
7. Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах;
8. Хурлыг хаах.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: 1-рт “Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах”

Танилцуулсан нь:

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг: Компанийн 2014 оны бизнес төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний гүйцэтгэл үр дүн, цаашдын зорилгын талаар танилцуулъя.

Өнгөрсөн жил Монгол улсад шингэн хүнс үйлдвэрлэж эхэлсэний 90 жилийн ой болсон. АПУ компани үүсгэн байгуулагдсаны 90 жилийн ой мөн тэмдэглэн өнгөрүүллээ. Уг хугацаанд асар их бүтээн байгууллалт хийж улс орны хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаа. Компанид 1000 орчим ажилчид ажиллаж байгаагаас гадна түгээгч болон бусад харилцагч компаниудтай нийлээд 1800 гаруй ажлын байр бий болгосон. 90 жилийн хугацаанд маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн. Ахмад үе, дунд үе, залуучуудын хамтарсан бүтээн байгуулалтын ажил байлаа.

2014 онд компанийн хэмжээнд томоохон ажил хийгдсэний нэг нь компанийн шинэ өнгө төрхийг тодорхойлон шинэчлэх ажил байлаа. Тухайлбал АПУ буюу Архи, Пиво, Ундаа гэсэн үгийг АРУ буюу Absolute, Pure, Unique энэ нь “Төгс, Төгөлдөр, Тунгалаг” гэсэн утга агуулгыг илэрхийлж, Монголчуудын эрт дээр үеээс бэлэгшээж ирсэн тулгын гурвын чулууны бэлэгдэл болж байгаа юм.

2014 он санхүү эдийн засгийн хувьд нилээн хүнд жил байсан бөгөөд түүхэндээ байхгүй алдагдал хүлээсэн нь нийт 14 тэрбум төгрөгийн алдагдал хүлээлээ. ТУЗ-р батлуулсан эрсдэлийн төлөвлөгөөний дагуу бид 22 тэрбум төгрөгийн алдагдал хүлээнэ гэж тооцолж байсанч 8 хувиар багасгаж чадсанаар 14 тэрбумын алдагдалтай ажилласан.

Бид цаашдаа таван жилийн урт хугацааны стратеги, төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Зардал багасгах, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахыг зорьж байгаа.

Экспортын үйл ажиллагааг ОХУ-с бусад улсад зогсоосон бус царцаасан. Бүрэн зогсоон гэж хэл болохгүй юм.

3 төсөл хэрэгжүүлсэн. Үүнд сүүний үйлдвэр, сүү цуглуулах цэг, ферм зэргийг байгуулж бүрэн ашиглалтанд оруулсан.

Улс орны болоод компанийн санхүү, эдийн засгийн байдал сайжиртал 1000 үнээний фермийн төслийг одоогийн байдлаар царцаагаад байгаа. Сүүний үйлдвэрт маш их хөрөнгө зарцуулсан.

Өнгөрсөн онд улсын төсөвт 167 тэрбум төгрөгийн татвар төлсөн. Сүүлийн 5 жилд нийт 540 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна.

Бид судалгаагаар архины зах зээлийн 70% эзэлдэг гэх боловч, бодит байдал дээр 59%, пивоны зах зээлийн 50%, бодит байдал дээр 39%, сүүний зах зээлийн 7% тус тус эзэлж байна. Компанийн үнэлгээ 7 хувиар буурч, 2014.12.31 хөрөнгийн биржийн үнэлгээгээр 278 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гарсан.

2015 оны борлуулалтын орлогыг 400 орчим тэрбум төгрөг, нийт хөрөнгө оруулалтын зардлыг 10 тэрбум орчим төгрөгөөр төлөвлөж байгаа. Уг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хийж буй хөрөнгө оруулалт байхгүй зөвхөн дотоод үйл ажиллагаа явуулах шаардлагатай жижиг хөрөнгө оруулалтууд болон зөвхөн өнгөрсөн хугацааны хөрөнгө оруулалтын үлдэгдэл төлбөрийг төлөх ажлууд л орсон.

2015 он эдийн засгийн хувьд маш хүнд байгаа. Өнгөрсөн хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд Европын сэргээн болголт хөгжлийн банк, Кредит Суйссаас авсан том зээлийн ачаар энэ бүтээн байгууллалтыг хийсэн. Уг зээлээс одоогийн байдлаар 10 орчим сая долларын буцаан төлөлт хийгдээд байгаа ба байдлаар бид үндсэн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлт гаргаад байна.

Бидний хувьд эдийн засгийн хямрал, үүнийг дагаад борлуулалтын хэмжээ үлэмж хэмжээгээр буурч байгаа, нөгөөтэйгүүр зээлийн дарамт, тэр дундаа ам.долларын ханшнаас шалтгаалан зээлийн дарамт маш их хүнд байна. Энэ үед гүйцэтгэх засаглал маш зөв бодлого явуулж байж энэ хямралаас гарна гэж бодож байна. Бид хөрөнгө оруулалтыг маш их тооцоолол гаргаж байж хийсэн учир хүндрэл учрахгүй байх гэж найдаж байгаа.

Эрх зүйн болон улс төрийн орчны тогтвортой бус байдал, төрийн зарим нэг эрх мэдэлтнүүд тодорхой судалгаа үндэслэлгүй хуулийн төсөл барьдаг нь, биелэлээ олохгүй популист хэлбэрээр ард түмэнд очиж сөрөг үр дагавар авчирч байна. Эрх зүйн тогтвортой бус байдал компанийн хувьд нилээд их хүндрэл учруулна хэмээн харж байна.

Ам.долларын ханш өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа. Удахгүй 2000 төгрөг болох байх. Ийм нөхцөлд бүтээгдэхүүний үнээ өсгөөчээ хэмээн асуудал тавих байх. Бид хувьцаат компани учираас бидний данс тунгалаг буюу нээлттэй байдаг. Зах зээлд өрсөлдөж байгаа учир өрсөлдөгч нарыхаа үнэтэй харилцан уялдаа холбоотой үнээ өсгөхгүй бол зах зээлд эзлэх хэмжээгээ алдах магадлалтай учираас аль болох бүтээгдэхүүний

нэгжийн үнийг өсгөхгүйгээр өртөгийг багасгаж, бүтээмжийг дээшлүүлэх талд анхаарч ажиллаж байна.

2015 оны төлөвлөгөөг танилцуулья. Хувьцаа эзэмшигчдийн хувьд тавих хамгийн чухал асуудал болох хэдий хэмжээний ашигтай ажиллах вэ, хэдэн төгрөгний ноогдол ашиг бидэнд хувиарлах вэ? гэсэн асуултанд, бид оны эхэнд хоёрдугаар сард баталсан Бизнес төлөвлөгөөнд 2015 онд 26 тэрбум төгрөгний цэвэр ашигтай ажиллана хэмээн тооцолж байгаа. Биелэлээ олоход маш хэцүү гэхдээ 2014 онтой харьцуулбал маш дээр үр дүн гарч ирнэ. Та бүхэнд асуулт байвал Санхүү хариуцсан захирал Б.Түвшин болон Стратегийн албаны холбогдох хүмүүстэй холбогдож уг тооцооллуудын талаар мэдээлэл авч болно.

Өнгөрсөн хугацаанд бид ногдол ашгийг аль болох өсгөж явья гэсэн бодлого барьж ажилласан. 2014 онд нэгж хувьцаандаа 90 төгрөгийн ногдол ашиг хувиарласан. Энэ нь 6,6 тэрбум төгрөгийн ногдол ашиг гэсэн үг ээ. Энэ нь 2013 онд 4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласаны үр дүн нөгөөтэйгүүр 2014 онд компани хувьд түүхэн жил ба үүсгэн байгуулагдсаны 90 жил болж буй учираас, бид бэлэгдлийг бодож, цаашдын өсөн дэвжих ирээдүйг бодож нэгж хувьцаа бүрт 90 төгрөгийн ногдол ашиг тараасан байгаа.

Зарим гадны хүмүүс уг шийдвэрийг ойлгохгүй, шүүмжлэлтэй хандах байх, гэхдээ бидний хувьд уг асуудал нь нэр төрийн хэрэг хэмээн авч үзсэн. Харамсалтай нь 2014 оны үйл ажиллагаа нь их хэмжээний алдагдалтай гарсан тул ногдол ашиг тараах боломж байхгүй байна.

Ингээд та бүхэнд 2014 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан 2015 оны төлөвлөгөөг товч танилцууллаа. Асуулт, хариултын хэсэгрүү орьё.

Асуулт: БиДиСек брокерын компанид бүртгэлтэй хувьцаа эзэмшигч Дуламжав байна.

1. Нэн түрүүнд талархал илэрхийлж, баяр хүргье нийт хувьцаа эзэмшигчдийхээ өмнөөс. Өнгөрсөн хугацаанд маш их хэмжээний хөрөнгө оруулалт, бүтээн байгууллалтын ажил хийж улс эх орондоо хувь нэмэр оруулж яваад дахин дахин талархал илэрхийлье. Түүнчлэн түрүүн үзүүлсэн тоонуудаас харахад алдагдалаас үл шалтгаалаад нилээд олон үзүүлэлт нэмэгдсэн дүр зураг харагдлаа. Тухайлбал борлуулалт 3,9 тэрбум гаруй төгрөгөөр нэмэгдсэн гэлээ.
2. Хувьцаа эзэмшигч бид нэг биш нилээд хэдэн компанид хувьцаа эзэмшдэг бөгөөд жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн хурал дандаа давцах юм аа. Жишээ нь жил жилийн хурал “Талх чихэр” ХК-тай давцах юм аа. Бидний хамгийн их суух сонирхолтой хоёр компани юм. Ирэх жилийн хурлыг 3 сард хийж болох уу?
3. 2015 онд ашигтай ажиллаарай гэж ерөөе. Ц.Эрдэнэбилэг захирлын багт баяр хүргээд их бүтээлч, их хэмжээний хөрөнгө оруулалт хийж ажилладагт баярлалаа.

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг: Магтаал, урмын үг хайрласанд баярлалаа. Компанийн баланс жил жилийн 2-р сарын 20-ны дотор гарч, үүний

дараагаар аудитын компани, манай компанийн хувьд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн компани болох КиПиЭмЖи /KPMG/ компаниар аудит хийлгэдэг. Аудитын дүгнэлтийн дараа хувьцаа эзэмшигдчийн хурал зохион байгуулах шаардлагатай холбогдуулж хурлыг 4-р сард зохион байгуулдаг байгаа. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг энд сууж байна. Ирэх онд бид боломжтой эсэхийг судлана.

Асуулт. Хувьцаа эзэмшигч Д.Цэдэндорж:

1. АПУ ХК дотоодын болон гадаадын хөрөнгийн бирж дээр нэмж хувьцаа гаргах уу, эсвэл бусад жишээ нь бонд өөр хэлбэрээр хөрөнгө босгох уу?

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг: Одоогийн байдлаар энэ асуудлаар тодорхой бодит шийдвэр гараагүй, асуудлыг авч хэлэлцээгүй. Гэхдээ ирээдүйд уг асуудал гарч болохыг үгүйсгэхгүй юм. Хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгох тохиолдолд нэмэлт хувьцаа гаргаж магадгүй. Гэхдээ нэн түрүүнд дотоодын зах зээлд хувьцаа гаргана.

Асуулт. Хувьцаа эзэмшигч Я.Энхсайхан: Дараах гурван асуултыг тавья:

1. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг хувиарлахгүй гэж ойлгож болох уу?
2. Ногдол ашиг, онцгой татвараас хамаардаг юм уу? Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээсээ ашгаа авах уу?
3. Үйлдвэр ашиглалтанд орсонтой холбогдуулж үйлдвэр үзэж болох уу. Хэр их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн, бүтээн байгуулалтыг үзмээр байна?

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг: 1. 2014 онд санхүүгийн хямралаас шалтгаалж их хэмжээний алдагдтай ажилласан учираас ногдол ашиг тараахгүй.

2. Ногдол ашиг, онцгой татвар хоорондоо шууд хамааралгүй ч гэсэн ашигт нөлөөлнө.
3. Үйлдвэр ашиглалтанд орсонтой холбогдуулж үйлдвэр үзэхэд хэн бүхэнд нээлттэй, зөвхөн хувьцаа эзэмшигчидэд ч бус хүн бүхэнд нээлттэй. Бид хэдийн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн, хэрхэн чанартай бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэдэг, түүнчлэн сүүлийн үеийн тоног төхөөрөмжтэй танилцуулах зорилтуудыг тавиад байгаа. Одоогоор ажилчид, албан хаагчид бүрийнхээ гэр бүлийхэнд Баасан гариг бүр үзүүлж байхаар тогтоод байгаа. Бид жил бүр 200,000 хүнд, сүүний үйлдвэрээ нийслэлийн хүүхдүүдийн 60 хувьд танилцуулья гэсэн зорилт тавиад байгаа.

Асуулт. Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч:

1. Онцгой албан татварыг ам.доллараар бус төгрөгөөр ногдуулах болсонд Эрдэнэбилэг захиралдаа баяр хүргье. Энэ бол маш том амжилт, баяр хүргье. Онцгой албан татварыг бууруулах, багасгах боломж нөхцөл байдаг уу? Бидний эрх ашигт шууд нөлөөлдөг. Уг асуудалд бид хэрхэн нөлөөлөх вэ, сэтгэл санаагаар ч гэсэн дэмжиж болно.

2. АПУ компанийхаа инженер техникийн ажилчдад баяр хүргэе. Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлдвэрээ авч явж буйд баярлалаа.

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг: Их чухал асуулт байна. Уг асуудлыг би шийдээгүй ээ. Асуудлыг цаг үетэй нь холбогдуулж зөв харж, нааштай шийдвэр гаргасан УИХ-даа талархал илэрхийлэх нь зөв байх. Мөн онцгой албан татвар ногдуулдаг бүтээгдэхүүн маань өөрөө нийгэмд эерэг, сөрөг нөлөө үзүүлдэг эмзэг бүтээгдэхүүн. Бидний чин хүсэл улс орон, төр засаг маань бодлоготой байж, эрх зүйн орчинг тогтвортой байлгаасай гэж хүсэж байна.

ОХУ архи, согтууруулан ундааны эсрэг нилээд хатуу бодлого явуулаад, өнгөрсөн 2014.12.22-д ОХУ-ын Ерөнхийлөгч мэдэгдэл хийсэн. Уг мэдэгдэлдээ: –Бид нар энэ бүтээгдэхүүнтэй ингэж тэмцээд болохгүй юм байна. Бид нарын хатуу тэмцэж, өндөр татвар ногдуулсаны үр дүнд үйлдвэрээс 5 шил үйлдвэрлэгдсэн гархад 2,5 литрт нь л онцгой албан татвар төлөгдөж 2,5 нь төлөгдөөгүй гарч байна. Өөрөөр хэлбэл 50 хувь саарал зах зээлтэй болсон байна гэжээ. Асуудлыг популист үзэл гаргалгүйгээр эдийн засгийн бодит тооцоогоор шийдвэрлэх боломжтой. Өнөөгийн байдалд бид эрх зүйн орчин тогтвортой байгаасай гэж их найдаж байна даа.

Асуулт. Хувьцаа эзэмшигч Н.Замбаа: 2014 он улс орон эдийн засгийн хувьд нилээн хэцүү жил болж өнгөрсөн. Үүний нөлөөгөөр манай бүх компаниудаад хүндээр туссан бөгөөд компаниуд мань уг асуудлыг тойрч биш дайрч гарсан. Энэ хямралыг давж чадахгүй олон компани давж чадахгүй хаалга барисан, ажилчин албан хаагчидаа цомхогтож байгаа. Богино хугацаанд тактик боловсруулж хямралыг гайгүй давж гарсан гэж хувьцаа эзэмшигчийн хувьд бодож байна. 2014 онд ТОП-100 компаниас 21-д жагссан байсан. Өнгөрсөн жилүүдэд эхний 10-д ордог байсан. 2015 оны бизнес үйл ажиллагааны дагуу хэвийн явбал хэдэд жагсах вэ?

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг: Тухайн үзүүлэлтийг цэвэр санхүүгийн үзүүлэлт, дүнгээр жагсаасан. Цэвэр ашгийн үзүүлэлтээр 100 компаниас 95-д орсон.

Асуулт. Хувьцаа эзэмшигч Д.Өлзийсайхан:

1. Түрүүн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулахаар хүсэлт гаргаад байгаа гэсэн. Европын сэргээн босголт хөгжлийн банк, Кредит суйсс банкнаас бусад өөр банкнаас зээл авсан уу?
2. Зээлийн эргэн төлөлт, тухайлбал графикийн талаар хүснэгтээр дэлгэрэнгүй мэдээлэл өгч болох уу? Түрүүн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах талаар хүсэлт гаргасан гэж байсан, хэдий хэмжээний зээлийг жилд төлөх үүрэгтэй вэ, тэрнээс одоогийн байдлаар 10 сая ам.долларыг төлсөн гэж байсан. Үүнтэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлтийг харж болох уу?

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг: Энэ асуудлыг нуух шаардлага байхгүй ээ. Нийт төслийн санхүүжилтийн 30 хувийг АПУ ХК өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн. Үлдэгдэл 70 хувийг Европын сэргээн босголт хөгжлийн банк буюу EBRD, Кредит Суйсс банк банкны зээлээс санхүүжүүлсэн. EBRD нь Австрийн RBI-тай хамтран синдикат зээл олгосон байгаа. 2014 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт 80 сая долларын өртэй байсан. Өнөөдрийн байдлаар 5 саяын зээлийг өгөөд 75 сая долларын өртэй байгаа. Үндсэн зээлээ хойшлуулах хүсэлтээ тавиад одоо нэг жил болж байгаа. Ирэх долоо хоногтоо компанийн удирдлагын баг зээлээ хойшлуулах хүсэлтийн дагуу Их Британийн Лондон хотноо очиж ажиллана. Шаардлагын хувьд дахин аудит хийлгээд 2019 он болж өгвөл 2021 хүртэл хойшлуулах хүсэлтэй байгаа. Жил бүр 16 сая ам.долларын зээл төлөх ёстой байгаа. Уг зээл нь эдийн засгийн хувьд ерөнхийдөө ашигтай зээл байгаа жилийн 6 хувийн хүүтэй, засгийн газраас 12 хувийн зээл авахаар хөөцөлдөж байхад.

Асуулт. Хувьцаа эзэмшигч М.Чулуун:

1. АПУ ХК-ийг үүсгэн байгуулагчдын нэг байна. Зах зээлийн харилцаанд ороход ид оролцож явсан хүн байна. Тухайн үед Гантөмөр гэж захирал ажиллаж байлаа, Оюунцэцэг гэж хүмүүс ажиллаж байлаа. Сэтгэлийн их халуун баяр хүргэмээр байна. Эрдэнэбилэг захирлынхаа ажиллаж буйг хараад сэтгэлийн их баяр хүргэмээр байна. Энэ хүнд үед 22 тэрбумын алдагдалтай ажиллана гэж байтал 14 тэрбум буюу 8 тэрбумаар багасгаж ажиллана гэдэг бол том амжилтаа. ТУЗ болон одоогийн гүйцэтгэх засаглалыг маш сайн ажилласан юм гэж дүгнэмээр байна. Их тэмцэжээ, хувьцаа эзэмшигчдээ ногдол ашиг өгөхийн төлөө их ажиллажээ.
2. 2015 онд амжилттай ажиллах юм байна. Энэ 4000 хувьцаа эзэмшигчдээ ногдол ашиг 90 төгрөгөөр бодож олгосонд дахин дахин талархал илэрхийлье. Би өөрөө уран бүтээлч хүн. 2015, 2016 ондоо сайн ажиллаад хувьцаа эзэмшигчдээ ногдол ашиг хувиарлана хэмээн найдаж байна.
3. Хөрөнгө оруулалтын асуудлуудыг маш зөв хийсэн байна. Гэхдээ гадаад харилцаагаа хөгжүүлж, зарж байгаа бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх тал дээр манай компанийн удирдлагууд анхаарч ажиллаарай. Амжилт хүсье.

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг: Таньд урмын үг хайрласанд талархал илэрхийлье. Таны үг анхааралдаа аван цаашдаа улам их хичээж зүтгэл гаргаж ажиллах болно.

Асуулт. Хувьцаа эзэмшигч Д.Намхай: Анх 76 ширхэг хувьцааг тарааж байхад хувьцааг Улаанбаатар хот, хөдөө цуг өгч байсан уу? Хөдөөний зарим хүмүүс би ямарч хувьцаа аваагүй та нэг асуугаад өгөөч гээд захих юм аа. Энийг хаанаас асуух вэ? Өвөрхангай аймгийн Баянцээл сумын Пүрэвжал овогтой Цадсүрэн гэдэг хүний хувьцааг асууж байна. Та бүхэнд сайн сайханыг хүсье.

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнбилэг: За бид хувьцаа, тархалтын мэдээг судалж үзэхэд нилээдгүй олон тооны хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл байдаагүй ээ, эзэн нь мэдэгддэгүй. Та манай ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг болон манай хуулийн зөвлөх мөн ҮЦТТХТ-тэй холбогдож уг мэдээллийг лавлаж асуух боломжтой.

Асуулт. Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Компанийн удирдлагатаа маш их талархал илэрхийлье. Жамьянсүрэнгийн үед компани маань ямар байлаа өнөөдөр ямар болоод байна, тэмээ ямаа хоёр шиг өөр гэдгийг хэн хүнгүй мэдэж байгаа байх. Жил бүхэн улсад төлсөн татвараараа хамгийн түрүүнд орж байдаг. АПУ компани маань хэдий ногдол ашиг төлөхгүй ч бидний хувьцааны үнийг 100 дахин өсгөсөн өөр компаний байхгүй ээ. Зөв зүйлд хөрөнгө оруулсан цагт бидний хувьцааны үнэ нэмэгдэж байгаад бид маш их талархалтай байна. Зээлээ л хурдан төлвөл энэ олон сайхан үйлдвэрүүд ашигаа өгнө. Шивээ овоо компанийн хуралд суусан, энэ компани үүсгэн байгуулагдсан цагаасаа нэг ч удаа ногдол ашиг төлж байгаагүй. Сүүний чиглэлээр хөрөнгө оруулсан маш зөв юм болсон, АПУ компанийн удирдлагадаа баярласнаа талархал илэрхийлье.

Асуулт, санал, хариулт дуусав.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг: хэлэлцэх асуудлын нэгдүгээр хэсэгт буй “АПУ ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан”-н талаар ТУЗ-н гаргасан дүгнэлийг батлах асуудлаар саналт хураалт явуулья.

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг: Уг асуудлаар саналт хураалт явуулья.

Саналт хураалт явуулж дуусав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ №2: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг: Бидний хэлэлцэх хоёрдугаар асуудал бол АПУ ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” асуудал байгаа. Одоо ажиллаж байгаа зарим гишүүд огцрох саналаа өгсөн тул Компанийн тухай хуулийн 77-д заасны дагуу “ТУЗ-ийг бүрэн хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай” асуудлыг хэлэлцэн санал хураая.

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг: Уг асуудлаар саналт хураалт явуулья.

Санал хураалт явуулж дуусав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ №3: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг: Бидний хэлэлцэх гуравдугаар асуудал бол АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн болон хараат нийт есөн гишүүдийг сонгох асуудал байгаа. Энэ шил шинээр нэр дэвшигч буй гишүүдийг танилцуулья. Хувьцаа эзэмшигч та ТУЗ-ийн энгийн гишүүдээс 6 сонгох, хараат бус гишүүдээс 3 сонгох эрхтэй ба та саналын хуудсаа зааварын дагуу

бөглөнө үү, буруу бөглөсөн тохиолдолд саналын хуудас хүчингүй болно гэдгийг анхаарна уу.

Тооллогын комиссын гишүүн кумулятив аргаар санал хураах аргыг тайлбарлав.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг дараах нэр дэвшигчдийг танилцуулав:

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

- Ердийн гишүүнд нэр дэвшигч : Хамхоев.Х.Ю

Мэргэжил:

Инженер, Эдийн засагч

Төгссөн сургууль:

1992 Карагандин хотын дээд сургууль
1982 Северо-Кавказский барилгын техникум,

Ажлын туршлага:

2000-одоог "Орион Интернейшнл ЛТД" Ерөнхий захирал
1986-1990 "Балхашский РЗК" Ажилтан, бэлтгэгч
1990-1992 "Лион ТОО" Дэд захирал
1992-1994 Браз Казакстан дахь төлөөлөгчийн газар, Худалдаа хариуцсан орлогч захирал

Бусад:

Улаанбаатар Менежмент КОО, ТУЗ-ын Дарга
УБ-БУК ХК, ТУЗ-ын гишүүн

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч : Марсел Бертод

Мэргэжил:

Худалдааны эдийн засагч

Төгссөн сургууль:

1992-1993 Парисын Арилжааны дээд сургууль
1980-1983 Наганума Япон хэлний дээд сургууль

Ажлын туршлага:

2008-одоог М Бертод Консалтинг ЛТД, Захирал
2006-2008 Еоп Яап Сэн, Дэд Ерөнхийлөгч
2003-2006 Япон, Солонгос Данон, ТУЗ-ын дарга
1999-2002 Ази номхон далайн Данон Ус Компани, Ерөнхийлөгч
1994-1998 Данон олон улсын брэнд компани, Ерөнхийлөгч, Төлөөлөгч Захирал
1990-1993 "Данон компани" Япон улсын Ажиномото бүс хариуцсан менежер
1984-1989 "Данон компани" Олон улс ойрх дорнодын экспорт хариуцсан менежер

Бусад:

Данон Энэтхэг, Якулт Вьетнам, ТУЗ-ын гишүүн

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч : Сиваев. А.В

Мэргэжил:

Эрхзүйч, Санхүү, эдийн засагч, Бизнесийн удирдлага

Төгссөн сургууль:

2012-2013 Москва хот Сколково удирдлагын сургууль

2012-2013 Лондон хот Захирлуудын дээд сургууль

1995-2003 Красноярский хот Улсын Их Сургууль

1997-1999 Красноярский хот Сибирийн сансар судлалын академи, БУ Сургууль

Ажлын туршлага:

2006-одоо Красный яр ЗАО, Ерөнхий захирал

2005.03-2006.02 Красный яр ЗАО, Санхүү хариуцсан захирал

2004.01-2005.03 "Оросын хөнгөн цагаан" холдинг "Инженер технологийн төв" ООО, Санхүү тооцооллын хэлтсийн дарга

2003.05-2003.10 "Оросын хөнгөн цагаан" холдинг "Тайшетийн хөнгөн цагаан үйлдвэр" ОАО, Санхүү хариуцсан захирал

1998-2001 "Оросын хөнгөн цагаан" холдинг Красноярскийн хөнгөн цагааны үйлдвэр, Төслийн албаны дарга

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч: Руперт Пёрсер

Мэргэжил:

Англи хэл судлаач

Төгссөн сургууль:

1986.07-1989.08 Лондонгийн Их Сургууль

Ажлын туршлага:

2010-одоо Turnaround Advisors Asia, Гүйцэтгэх захирал

2012.09-2013.06 PWC Consulting Hong Kong, Зөвлөх, Гүйцэтгэх Захирал

2006-2010 "Terramillem Capital Limited", Гүйцэтгэх захирал, Шинэ харилцаа холбооны хөрөнгө оруулалтын дарга

2001-2006 "Baker Tilly Hong Kong", Гүйцэтгэх захирал, Байгууллагын Санхүү Зөвлөхийн дарга

- Хараат бус гишүүнд нэр дэвшигч: С.Эрдэнэ

Мэргэжил:

Хуульч, эрхзүйч

Төгссөн сургууль:

1985-1990 Дотоод явдлын яамны дээд сургууль

Ажлын туршлага:

2014-одоо Нарта констракшн ХХК, 100% хувьцаа эзэмшигч, ТУЗ-ын дарга

2013-одоо Нарта ХХК, 100% хувьцаа эзэмшигч, ТУЗ-ын дарга

2000-одоо ЭДКС ХХК, 100% хувьцаа эзэмшигч, ТУЗ-ын дарга

1990-1993 Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар, Төлөөлөгч

1993-2000 Чингилтэй дүүргийн цагдаагийн хэлтэс, Төлөөлөгч, Тасгийн дарга

Бусад:

Нарта Сэлэнгэ ХХК, 50% хувьцаа эзэмшигч

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг: Уг асуудлаар санал хураалт явуулья.

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга Ю.Болорцэцэг: Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролсон саналын эрхтэй хувьцаа /69,969,851 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролсон саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролсон саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
74,287,700	100%	69,876,723	99%	74,287,700	100%	1,774	0,000025	74,287,700	100%	0	0

2. “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” асуудлаар:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролсон саналын эрхтэй хувьцаа /69,969,851 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролсон саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /74,287,700 ширхэг/		Хуралд оролсон саналын эрхтэй хувьцаа /69,826,365 ширхэг/	
тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
74,287,700	100%	69,876,723	99%	74,287,700	100%	1,736	0,000025	74,287,700	100%	0	0

3. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнийг кумулятив аргаар сонгох” асуудлаар:

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1. П.Батсайхан	69,887,717
2. П.Батчимэг	69,872,790
3. Б.Батбаяр	69,820,292
4. Громов. С.Б	69,795,632
5. Хьюго Баретт	69,805,042

6. Трэвис Хамилтон	80,275
7. Хамхоев. Х.Ю	69,734,802

Үүнээс ТУЗ-ийн энгийн гишүүнд: П.Батсайхан, П.Батчимэг, Б.Батбаяр, Громов.С.Б, Хьюго Баррет, Хамхоев. Х.Ю нар сонгогдов.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид	Кумулятив аргаар санал өгсөн саналын эрхийн тоо
1. С.Эрдэнэ	69,778,840
2. Сиваев. А.В	69,761,351
3. Ж.Үнэнбат	69,779,910
4. Марсель Бердотт	12,787
5. Руперт Пёрсер	15,323

Үүнээс: ТУЗ-ийн хараат бус гишүүнд: С.Эрдэнэ, Сиваев. А.В, Ж.Үнэнбат нар сонгогдов.

Саналын эрхтэй 92,387 ширхэг хувьцаатай 20 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

Хурлын шийдвэр:

Хурлын дарга, гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн 2015 он ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. АПУ ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлав.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор шийдвэрлэв.
3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр П.Батсайхан, П.Батчимэг, Б.Батбаяр, Громов.С.Б, Хьюго Баррет, Хамхоев. Х.Ю нарыг, хараат бус гишүүдээр С.Эрдэнэ, Сиваев. А.В, Ж.Үнэнбат нарыг сонгов. Сонгогдсон гишүүдээ амжилт хүсье гэснээр ээлжит хурлыг хаав.

Хурал 16 цаг 48 минутанд дуусав.

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ц.Эрдэнэбилэг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

Нарийн бичгийн дарга

Sara

Б.Сарантунгалаг